

**МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭГ ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД
ТУСГАЖ БУЙ БАЙДАЛ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БА ҮНДЭСНИЙ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХАРИЛЦАН ХАМААРЛЫН ТУХАЙ ОНОЛ,
ОЛОН УЛСЫН ХАНДЛАГА
(Мэдээлэл лавлагаа)**

Д. Живгаагүнсэл, Ө.Мөнхтунгалаг, Р.Нургул

ОРШИЛ

Судалгааны зорилго

Энэхүү судалгаагаар Монгол Улсын олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид тусгаж буй байдал, олон улсын гэрээ үндэсний хууль тогтоомжийн харилцан хамаарлын тухай онол арга зүй, олон улсын хандлагад тулгуурлан харьцуулан гаргахыг зорьсон болно.

Судалгаа мэдээллийн эх сурвалж

Судалгааны сэдвийн Монгол Улсын олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн хэрэглэж байгаа эрх зүйн зохицуулалтын талаарх бодлогын баримт бичгүүд, Гадаад хэргийн яамны Гэрээ, эрх зүйн газраас ирүүлсэн Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцын талаар мэдээлэл, УИХ-ын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсээс ирүүлсэн мэдээлэл, гадаадын зарим улс орны үндсэн хуулийн албан бус орчуулга, энэ чиглэлээр хийгдсэн судалгааны ажлын зарим мэдээллийг ашиглав.

Судалгааны дүгнэлт

Олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх асуудлыг манай улс олон улсын практикт хэрэглэдэг дуалист хандлагыг баримталдаг бөгөөд 1992 оны Үндсэн хууль, 1993 оны Олон улсын гэрээний тухай хууль, олон улсын гэрээг соёрхон баталсан хуулиуд эх сурвалж болдог байна.

Монгол Улс ардчилал, зах зээлийн замыг сонгож, шинэ ардчилсан Үндсэн хууль баталснаар Олон улсын гэрээг хэрэглэх, түүнийг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх эрх зүйн зохицуулалтыг шинээр нээж, хуульчлан баталгаажуулсан байна. Ингэхдээ дотоодын хууль тогтоомж Монгол Улсын олон улсын гэрээтэй зөрчилдөх тохиолдолд олон улсын гэрээний заалт давуу хүчинтэй байхаар зохицуулжээ. *Тухайлбал,*

Өнөөгийн байдлаар манай улс 287 олон талт гэрээнд нэгдэн орж,¹⁵⁶ 2014 оны 05 дугаар сарын байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй 423 хуулийн 159 гаруйд нь *“Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө”* гэж заасан байна.¹⁵⁷

Гэхдээ зөвхөн хууль хэлбэрээр хүлээн зөвшөөрсөн олон улсын гэрээ л дотоодын хуулиас давуу хүчинтэй байх бөгөөд олон улсын гэрээний зохицуулалт дотоодын хуулийн зохицуулалтаас өөр байвал олон улсын гэрээний заалт үйлчилнэ. Хэдийгээр олон улсын эрх зүй дотоодын хууль тогтоомжоос давуу боловч Үндсэн хуульд харшилсан олон улсын гэрээг Монгол Улс дагаж мөрдөхгүй.

Харин Олон улсын гэрээний тухай хуулийн 19 дүгээр зүйлд *“Монгол Улсын яам, тусгай газар болон тухайн гэрээгээр зохицуулж байгаа асуудлын хүрээнд хамрагдах бусад байгууллага Монголын талын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангана”*, мөн

¹⁵⁶ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газраас ирүүлсэн мэдээлэл, 2014.05.30.

¹⁵⁷УИХ-ын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсээс ирүүлсэн мэдээлэл, 2014.05.29.

27.1-д “Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн бусад актад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дангаар, эсхүл холбогдох яам, тусгай газартай хамтран Засгийн газарт өргөн мэдүүлнэ” гэж заасны дагуу олон улсын гэрээний биелэлтийг холбогдох асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хариуцаж, шаардлагатай тохиолдолд дотоодын хууль тогтоомжийг олон улсын гэрээнд нийцүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авдаг байна.

Олон улсын гэрээний гол эх сурвалжууд нь 1969 оны гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц, 1986 оны Улс гүрнүүдийн болон олон улсын Засгийн газар хоорондын гэрээний эрх зүйн тухай конвенц, 1978 оны гэрээний эрх зүйн өвлөлийн тухай Венийн конвенц, 1945 оны НҮБ-ын дүрэм зэрэг юм.

Дэлхийн ихэнх улс орнууд олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэхдээ Кельзений онол буюу Монист хандлагыг хүлээн зөвшөөрч хэрэглэдэг ч олон улсын гэрээний хувьд монист гэхээсээ илүүтэйгээр дуалист, монист хандлагуудыг хамтад нь хэрэглэдэг бөгөөд ингэхдээ Үндсэн хуулийн болон бусад механизмаар зохицуулахаас гадна олон улсын эрх зүйн акт тус бүрийн онцлог шинжээс хамааран гэрээний эрх зүйн өөр өөр дүрэм, журам мөрдөгддөг.

Судалгааны сэдвийн хүрээнд Англи, АНУ, ОХУ, Франц, Португали, Испани, Израйль, ХБНГУ, БНСУ, Швейцарь зэрэг улс орнуудыг авч үзэхэд ихэнх нь олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомждоо нийцүүлэхдээ Үндсэн хуулийн механизмаар зохицуулсан байна. Ингэхдээ үндэсний хууль тогтоомж нь олон улсын гэрээний заалттай нийцсэн байх ба олон улсын гэрээ нь үндэсний хууль тогтоомжоос давуу эрхтэй байхаар хуульчилжээ. /*Дэлгэрэнгүй мэдээллийг судалгаанаас үзнэ үү.*/

Нэг. Монгол Улсын олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид тусгаж буй байдал

Монгол Улс ардчилал, зах зээлийн замыг сонгож, шинэ ардчилсан Үндсэн хууль баталснаар олон улсын гэрээг хэрэглэх, түүнийг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх эрх зүйн зохицуулалтыг шинээр нээж, хуульчлан баталгаажуулсан байна.

Олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх асуудлыг манай улс олон улсын практикт хэрэглэдэг дуалист хандлагаар шийдсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд *“Олон улсын эрх зүйн нийтээр зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх, олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэх тухай заалтууд тусгагдсан. Үндсэн хуульд харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй гэдгээ ч хуульчлан баталгаажуулсан.*

Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3-т *“Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”* гэсэн нь Үндсэн хуулийнхаа механизмаар олон улсын гэрээнд тодорхой “босго” тавьж, шүүж тухайн гэрээг дотоодын хууль тогтоомжтой нэгэн адил хэрэглэх, эс хэрэглэхээ шийднэ гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын шүүх зөвхөн ийм олон улсын гэрээ, хэлэлцээрийг шүүн таслах ажиллагаандаа баримт болгон ашиглах болно гэсэн үг.

Олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжоос давамгайлах хүчинтэй байдаг. Олон Улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцын 27 дугаар зүйлд зааснаар гэрээнд оролцогч улс гүрэн *“гэрээ биелүүлээгүй явдлаа дотоодын хууль тогтоомжийн заалтаар*

зөвтгөж үл болно” гэжээ. Энэхүү зарчмын дагуу үндэсний хууль тогтоомж нь олон улсын гэрээний заалттай нийцсэн байх ёстой. Гэхдээ тэдгээрийн хооронд аливаа зөрүү гарвал олон улсын гэрээг дагаж мөрддөг. Үүнтэй холбогдуулан олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжоос давуу эрхтэй хэмээн үзэж, хэрэглэж болох талаар 2014 оны 05 дугаар сарын байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй 423 хуулийн 159 гаруйд нь “Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасан байна.¹⁵⁸

Хоёр. Олон улсын гэрээ ба үндэсний хууль тогтоомжийн харилцан хамаарлын онол, олон улсын хандлага

Олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомждоо хэрхэн нийцүүлэх, хэрэглэх вэ гэдэг асуудлаар үндсэндээ гурван онол буюу үзэл баримтлал оршсоор ирсэн.

Нэгдүгээрт, Үндэсний эрх зүй, хууль тогтоомжоо олон улсын эрх зүй /ОУЭЗ/, түүний хэм хэмжээнээс дээгүүр тавих. Энэ онолыг Германы философич Гегель XIX зуунд дэвшүүлж тавьсан байдаг.

Хоёрдугаарт, Дуализм /хосолмол/-ын онол нь олон улсын эрх зүй, үндэсний эрх зүй нь бие биенээсээ тусдаа үл хамаарах байдлаар оршдог гэж үздэг.

Гуравдугаарт, Монист онол. Дэлхийн нэгдүгээр дайны дараагаар Австрийн хуульч Г.Кельзен дотоодын эрх зүйн хэм хэмжээнээс олон улсын эрх зүйн хэм хэмжээ давуу байх онолыг дэвшүүлэн тавьсан байна. Эдгээр онол, үзэл баримтлалыг арай дэлгэрүүлэн авч үзье.

Монист онол¹⁵⁹ нь Олон улсын эрх зүй, үндэсний эрх зүй нь бүхэл нэг систем бөгөөд ямар нэгэн нөхцөл байдлаас хамааран олон улсын эрх зүй ба үндэсний эрх зүй дээдлэгдэх ёстой гэж үздэг. Энэ онол нь Радикал, Негалист гэсэн 2 урсгалтай бөгөөд эдгээр нь өөр өөрийн гэсэн үзэл баримтлалтай байдаг.

- a) *Негалист* буюу үндэсний эрх зүйг дээдлэх үзэл нь 19-р зууны үеэс бий болсон. Германы эрдэмтэн А.Цорс, А.Лассон нар Гегелийн олон улсын эрх зүй бол улсын гадаадын эрх зүй гэсэн үзэлд тулгуурлан үзэл баримтлалыг үүсгэн хөгжүүлсэн энэ үзэл нь үндэсний эрх зүй олон улсын эрх зүйд агуулагдана гэсэн санааг гаргаж ирсэн.
- b) *Радикал* үзлийн гол төлөөлөгч нь Г.Кельзен юм. Энэ урсгал нь “төрийн бүрэн эрхт байдлыг үгүйсгэдэг гэж шүүмжлэлд өртөж байсан бол орчин үед прагматик радикал маягаар хөгжиж ирснээр олон улсын эрх зүйн давуу байдлыг хүлээн зөвшөөрч ингэснээр улс орнууд хөгжлийн байдал бусад нөхцөл байдлаас үл шалтгаалан олон улсын эрх зүйн харилцаанд тэгш эрхтэй оролцох болно” гэж үзэх болсон. Олон улсын эрх зүй давуу байдалтай байснаар олон улсын аюулгүй байдал түүнийг бэхжүүлэх зэвсэгт мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх дотоод гадаад бодлогодоо олон улсын эрх зүйг давуу байдлаар үзсэнээр энх тайван байдлыг бэхжүүлэх нь гол үндэс гэж үздэг. Олон улсын эрх зүй, үндэсний эрх зүйгээс давуу байх талаар тунхагласан гол баримт бичиг бол 1969 оны Гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц юм. Тус конвенцын 27 дугаар зүйлд “Оролцогч улсууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйг зөвтгөх зорилгоор өөрийн орны дотоодын эрх зүйн заалтыг ишлэж болохгүй” гэж заасан байдаг байна.

¹⁵⁸УИХ-ын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсээс ирүүлсэн мэдээлэл. 2014.05.29.

¹⁵⁹<http://www.unimis.mn/teacher/upload/433PEPLEK.ppt> - Олон улсын эрх зүй.

Дуалист онолыг мөн уян хатан, радикал гэж 2 ангилдаг. Энэ онолоор олон улсын эрх зүй, үндэсний эрх зүй нь бие биенээсээ тусдаа үл хамаарах байдлаар оршдог гэж үздэг. Ингэж үзэхдээ зохицуулах объект эрх зүйн харилцааны субъект, эрх зүйн эх сурвалжаараа өөр гэдгээр үндэс болгодог. Энэ үзлийг баримтлагчид хэдийгээр хамааралгүй гэж үзсэн боловч олон улсын эрх зүй Үндэсний эрх зүйд тулгуурлан бий болж улмаар олон улсын эрх зүйн хэрэгжилтийг хангахад дэмжлэг авдаг гэж үздэг.

Олон улсын эрх зүй үндэсний эрх зүйг уялдуулах дараах зарчим байдаг. Үүнд:

- 1) Ишлэл хийх;
- 2) Хувиргах;
- 3) Зэрэгцүүлэн хууль тогтоох;
- 4) Шилжүүлэх;
- 5) Хуулбарлах.

Ишлэл хийх нь дараах байдлаар илэрсэн байдаг. Монгол Улсын Иргэний хуулийн 2-р зүйлийн 2-т “Монгол Улсын Олон улсын гэрээнд хуульд зааснаас өөрөөр заасан бол Олон улсын гэрээг дагаж мөрдөнө.” гэж заасан байдаг.

Хувиргах: Олон улсын хэм хэмжээг авч өөрийн улсын онцлогт тохируулах замаар хэм хэмжээг авч хэрэглэх;

Хуулбарлах: өөр улсын хэм хэмжээг шууд авах замаар өөрийн улсын эрх зүйн хэм хэмжээнд буулгах;

Шилжүүлэх зарчмыг шууд ба шууд бус гэж ангилдаг.

Шууд шилжүүлэх: нэгдэн орсон Олон улсын гэрээ нь шууд хуулийн хүчинтэй болж үйлчлэхийг хэлдэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 зүйлийн 3-т зааснаар “Монгол Улс олон улсын гэрээг соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хуулийн нэгэн адил үйлчилнэ” гэж заасан.

- с) Шууд бус шилжүүлэх: Олон улсын гэрээ үйлчлэх аргыг Үндсэн хууль болон бусад хуульд зааж өгсөн байдаг. Испани улсын Үндсэн хуулийн 96 дугаар зүйлд “албан ёсоор нийтлэгдсэн олон улсын гэрээ дотоодын хууль тогтоомжийн бүрэлдэхүүн хэсэг болно” гэж заасан байдаг.

Зэрэгцүүлэн хууль тогтоох: Энэ нь олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн хууль гаргана гэсэн үг биш өөрийн дотоодын хэрэгцээндээ зориулан хууль гаргах замаар гэрээ конвенцид нэгдэхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл нэгдэж батлахыг хэлнэ.

Дуализм (хосолмол) онол буюу заримдаа трансформаци хандлага ч хэмээдэг энэ онол нь олон улсын эрх зүй болон дотоодын эрх зүйг, эрх зүйн тус тусдаа хоёр өөр систем хэмээн салангид авч үздэг бөгөөд аливаа олон улсын гэрээг үндэснийхээ хууль тогтоомжид нийцүүлэхдээ, тухайн улсын хууль тогтоогч дээд байгууллагаас нь тусгайлан хууль гарган дотоодын хуульдаа нийцүүлдэг бөгөөд үүнийгээ Үндсэн хуулийн механизмаар зохицуулсан байдаг байна.¹⁶⁰

Өнөөдөр дэлхийн ихэнх улс орон Кельзений энэхүү үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрч мөрдөж байна. Гэхдээ олон улсын эрх зүй, ялангуяа түүний үндсэн эх сурвалжийн нэг болох олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх асуудал олонхи улс орон болгоомжтой, хүлээцтэй хандаж байна.

¹⁶⁰“Олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлж хэрэглэх нь”, ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын захирал, Хууль зүйн шинжлэх ухааны доктор Б.Алтангэрэл, “Хууль дээдлэх ёс”, 2006 он, №4, 94 дүгээр тал.

Өөрөөр хэлбэл, олон улсын эрх зүйн актуудыг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэхдээ, Үндсэн хуулийнхаа заалтын дагуу тэдгээрийг парламентаараа заавал соёрхон баталж байж хүчин төгөлдөр болгох буюу хувиргах /трансформаци/ механизмын арга замаар нийцүүлэх асуудал юм.

Кельзений онолыг заримдаа Монизм буюу инкорпораци /нэгтгэх, нийлүүлэх/ хандлага хэмээн нэрлэдэг.

Энэ нь олон улсын эрх зүйг дотоодын эрх зүйн нэгэн салшгүй хэмээн үзэж, олон улсын эрх зүйн актууд нь автоматаар тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил шууд хэрэглэгддэг бөгөөд, тэдгээрийг хүчин төгөлдөр болгон дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэх нь илүү хялбар мэт харагдах боловч, эл хандлагыг хэрэглэх үед олон улсын эрх зүйн акт тус бүрийн онцлог шинжээс хамааран гэрээний эрх зүйн өөр өөр дүрэм, журам мөрдөгддөг.

Ихэнх улс орон дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэхдээ монист, дуалист хандлагуудыг хамтад нь хэрэглэсэн байдгийг доорх жишээнээс харж болно.

Англи улс¹⁶¹ XVIII зуунаас эхлэн монист хандлагыг хэрэглэж ирсэн боловч энэ нь зөвхөн олон улсын зан заншлын эрх зүйд хамаардаг бөгөөд олон улсын гэрээний хувьд зарим гэрээг, жишээ нь Британийн Хатан хаан гарын үсэг зурж, батлах авч түүнийг нь Английн шүүх шууд авч хэрэглэдэггүй бөгөөд заавал Английн парламентын актаар баталсан байх ёстой. Гэхдээ олон улсын бүхий л гэрээнд нь хамаардаггүй бөгөөд “харьцангуй чухал биш” /relatively unimportant/ хэмээн үзсэн гэрээг парламентаар заавал соёрхон батлах шаардлагагүй байдаг байна.

АНУ-ын хувьд монист хандлагыг хэрэглэдэг гэх боловч олон улсын гэрээний хувьд: АНУ-ын Үндсэн хуулийн 2 дугаар заалтад *“Ерөнхийлөгч олон улсын гэрээ байгуулах бүрэн эрхтэй бөгөөд Сенатын танхимын гишүүдийн гуравны хоёр нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд түүнийг соёрхон батална”* хэмээн заасан байдаг.

Франц улсын хувьд олон улсын гэрээг соёрхон батлахгүйгээр, зөвхөн хууль гарган үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэдэг байна. Гэхдээ Францын Үндсэн хуулийн 55 дугаар зүйлд зарим нэг олон улсын гэрээний тодорхой заалтууд нь дотоодын хууль тогтоомжоос давуу эрхтэй байж болно хэмээн заасан байдаг.

ОХУ шинэ Үндсэн хуулиа 1993 онд баталсан бөгөөд Үндсэн хуулийн 86 дугаар зүйлийн дагуу *“Ерөнхийлөгч олон улсын гэрээг хэлэлцэх, түүнд гарын үсэг зурах, Соёрхон батлах, эсхүл цуцлах ёстой олон улсын гэрээг заавал хянан үзэх шаардлагатай байдаг. Үндсэн хуулийн шүүх нь мөн хүчин төгөлдөр болоогүй олон улсын гэрээг Үндсэн хуульд нийцэх буй эсэхийг хянах, хэрэв Үндсэн хуультай зөрчилдөж байна гэж үзвэл хүчин төгөлдөр болоход хориг тавих эрхтэй. ОХУ-ын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 4-т “Олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд ба хэм хэмжээ болон ОХУ-ын олон улсын гэрээг түүний эрх зүйн системийн нэг хэсэг хэмээн үзнэ. Хэрэв ОХУ-ын олон улсын гэрээ нь хууль тогтоомжид зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг хэрэглэнэ”* хэмээн заасан байдаг нь олон улсын зан заншлын эрх зүй болон гэрээний эрх зүйг ОХУ-ын дотоодын хууль тогтоомжоос илүү эрхтэй байхаар тодорхой зааж өгсөн байна.

Ихэнх улс орон монист хандлагатай ба олон улсын эрх зүйг үндэсний эрх зүйгээс давуу хүчин чадалтай гэж үздэг. Монист хандлагатай улс орны хувьд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх арга нь ишлэл хийх арга байдаг. Ишлэл хийх аргын гол ач холбогдол нь олон улсын эрх зүйг давуу байдлаар авч үздэг. Тухайлбал,

¹⁶¹<http://www.lexadin.nl/wlg/legis/nofr/legis.php>

Португалийн Үндсэн хуульд *“хүний эрхийн тунхаглалыг баримт болгоно”* гэж заасан байдаг байна. Мөн Олон улсын гэрээ үйлчлэх аргыг Үндсэн хууль болон бусад хуульд зааж өгсөн байдаг.

Испанийн Үндсэн хуулийн 96 дугаар зүйлд *“албан ёсоор нийтлэгдсэн олон улсын гэрээ дотоодын хууль тогтоомжийн бүрэлдэхүүн хэсэг болно”* гэж заасан байдаг.

Дуалист онолын хандлагатай улсад Канад, Швед, Англи, Израйль гэх мэт улс орнууд орох бөгөөд олон улсын хэм хэмжээг өөрийн нутаг дэвсгэр дээр тодорхой хууль хэлбэрээр буулган авсан тохиолдолд хэрэглэдэг. Жишээлбэл,

Израилийн Үндсэн хуулийн 108 дугаар зүйлд *“олон улсын гэрээ нь дотоодын эрх зүйн хүрээнд зөвхөн хуулийн хүчээр үйлчилнэ”* гэж заасан байдаг.

Солонгосын үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 7 дугаар зүйлд *“Үндсэн хуульд нийцүүлэн батлан гаргасан зарлан тунхагласан эрх зүйн акт болон олон улсын нэгдэн орсон гэрээ нь дотоодын хууль тогтоомжтой адил үйлчилнэ”* гэжээ.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 32 дугаар зүйлд *“Гадаад улс оронтой харилцахыг Холбоо хариуцна. Герман улс олон улсын гэрээ байгуулахад муж улсын онцгой нөхцөл байдал хөндөгдөхөөр байвал тухайн муж улсын саналыг урьдчилан сонссон байвал зохино. Муж улсууд хууль тогтоох эрхийнхээ хүрээнд Холбооны Засгийн газрын зөвшөөрөлтэйгээр гадаад улстай гэрээ байгуулж болно.”*

“Олон улсын түгээмэл эрх зүйн үндсэн дүрмүүд нь холбооны хууль тогтоомжийн нэгэн салшгүй хэсэг бөгөөд тэдгээр нь холбооны нутаг дэвсгэр дээр оршин суугчдад үүрэг, хариуцлага шууд үүсгэж, хууль тогтоомжоос илүү давамгай байна” хэмээн заасан нь олон улсын эрх зүйн үндсэн зарчмууд нь дотоодын хууль тогтоомжийг хүчингүй болгох эрхтэй эсэх, эсхүл Үндсэн хуулийг нь хүртэл хөндөж болох эсэх асуудлаар санал зөрөлдөөн үүсгэж, саармаг ойлголт төрүүлдэг хэмээн үздэг.

Гэхдээ олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжтой нийцүүлэх асуудлаар Германы үндсэн хуулийн 59 дүгээр заалтад тодорхой тусгаж өгсөн. Үүнд: *“Холбооны улс төрийн харилцааг зохицуулж буй, эсхүл холбооны эрх зүйн асуудлыг хөндөж буй олон улсын гэрээний хувьд холбогдох хууль эрх зүйн байгууллагуудын зөвшөөрөл, эсхүл оролцоо шаардлагатай бөгөөд үүний дараагаар тухайн гэрээг Германы хуульд нэгтгэн хэрэглэх бөгөөд, чингэхдээ холбооны хуулиас давуу биш, ижил түвшинд хэрэглэнэ”* хэмээн заажээ.

Швейцарь Улсад олон улсын гэрээг засгийн газарт (Холбооны зөвлөл) урьдчилан эрх олгоогүй бол Швейцарийн Парламент (Холбооны Ассамблей) баталдаг. Швейцарийн сонгогчид нь үндэсний хууль тогтоомжид нөлөөлөх аливаа олон улсын гэрээний талаар сонголтот санал асуулга явуулах эрхтэй байдаг. Зарим тохиолдолд тухайлбал, НҮБ, Европын Холбоонд элсэн орох зэрэг чухал гэрээ батлах бол заавал санал асуулга явуулдаг байна. Дэлхийд өөр ямар ч улс орон Швейцарийн нэгэн адил олон улсын гэрээг хамтран тодорхойлох эрхийг ард иргэддээ олгодоггүй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газраас ирүүлсэн мэдээлэл, 2014.05.30.
- УИХ-ын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсээс ирүүлсэн мэдээлэл, 2014.05.29.
- “Олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид нийцүүлж хэрэглэх нь”, ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газрын захирал, Хууль зүйн шинжлэх ухааны доктор Б.Алтангэрэл, “Хууль дээдлэх ёс”, 2006 он, №4, 94 дүгээр тал.
- <http://www.unimis.mn/teacher/upload/-Олон улсын эрх зүй>.
- <http://www.lexadin.nl/wlg/legis/nofr/legis.php>